



**ХЭНТИЙ АЙМАГ
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/64

Бор-Өндөр

**Эзэмшсэн газрын эзэмших төрлийг
өөрчлөх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь заалт, Газрын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Бор-Өндөр сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэр, Үйлдвэрлэлийн бүс, Шинэ зам-205 тоот хаягт байрлалтай, Уул уурхайн үйлдвэрлэлийн зориулалттай, 119830 мкв газрын 3789347 нэгж талбар бүхий газрын дуудлага худалдаанд ялалт байгуулсан гадаадын хөрөнгө оруулалттай "Сити сүлжээ" ХХК /РД:5021065/-д тухайн газрыг эзэмшүүлснийг Газрын тухай хуулийн дагуу ашиглах болгож зөрчлийг арилган газар ашиглах эрхийн гэрчилгээг олгосугай.

2. Газар ашиглах эрхийн гэрчилгээ авсан "Сити сүлжээ" ХХК-ийн захиралтай гэрээ байгуулан, гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Т.Эрдэнэзаяа)-д даалгасугай.


3. Уг захирамж гарсантай холбогдуулан Сумын Засаг даргын 2024 оны А/256 дугаар захирамжийн "Сити сүлжээ" ХХК-д холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

4. Газар ашиглуулах гэрээнд заасан зориулалт, нөхцлийн дагуу газраа ашиглан, гэрээг жил бүр дүгнүүлж байхыг "Сити сүлжээ" ХХК-ний захиралд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ



Газар болон ашиглагчийн мэдээлэл

Иргэн /хуулийн этгээд/-ийн нэр	Регистр	Өмнөх Захирамжийн			
		Огноо	Дугаар	Хавсралтын дугаар	Холбогдох хэсгийн дугаар
1	2	3	4	5	6
Ричнай ХХК	5489768	2012.02.01	18	1	1
Өмнөх газрын					
Газрын					
Нэгж талбарын дугаар	Хэмжээ /мкв/	Хэмжээ /мкв/	Ашиглах хугацаа /жил/	Ашиглах зориулалт	Байршил
7	8	9	10	11	12
221000004	27595	27556	5	Уул уурхайн үйлдвэрлэлийн барилга, байгууламж	2-р баг, Үйлдвэр-1 гудамж, 105 тоот